



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

2005 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Дархан

Дугаар 79

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дугаар заалт, Засгийн газрын 1993 оны 57 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Тус аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Их дээд сургууль, коллежид суралцагсдын үзэж судлах эрх зүйн хичээлийн хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Хаянхярваа/-д үүрэг болгосугай.

ДАРГА Л.ГҮНЧИН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ